

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 07 сарын 03 өдөр

Дугаар A/27

Арвайхээр сум

**Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай
зөвшөөрөл сунгах тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3,19.14, 19.15, 19.18, дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 07 дүгээр сарын 01-ний өдрийн шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргалд)-т үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН УҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБАЯР

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 дугаар сарын 07-ны
өдрийн 1/17 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл сунгах хугацаа	Хүчинтэй байх хугацаа/огноо
1	“Энх-Амар” хувийн хэвшлийн эмийн сан РД-3561755 Дугаар№ ЭХ-20/13/84	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Хужирт сум 4-р баг	5 жилээр	2030 оны 07 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл
2	“Гэрэлт-Амирлангуй” клиник РД-3555941 Дугаар№ ЭХ-13/21/109	Эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ	Арвайхээр сум 5-р баг	5 жилээр	2030 оны 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл
3	“Оточ Энэрэхүй” клиник РД-3560678 Дугаар№ ЭХ-13/21/107	Эмэгтэйчүүд, мэс засал, дүрс оношилгооны, тусламж үйлчилгээ	Арвайхээр сум 13-р баг 204-р байр 03 тоот	5 жилээр	2030 оны 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл
4	“Хүслэн” шүдний эмнэлэг РД-3566919 Дугаар№ ЭХ-13/19/42	Шүдний оношилгоо, эмчилгээ	Арвайхээр сум 5-р баг Гэндэнгийн гудамж, 209-р байр	5 жилээр	2029 оны 05 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 дугаар сарын 01-ны
өдрийн 1127 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Нэмэлт өөрчлөлтийн агуулга
1	"Энх Оргил ЖАЗ" нийтийн үйлчилгээтэй эмийн сан РД-3562751 Дугаар№ ЭХ- 20/13/81	Эм, эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны худалдаа	Арвайхээр сум 5-р баг	Арвайхээр сумын 3-р багийн "Хос арвижих" төвийн 2 давхарт түр байршиж үйлчилгээ явуулж байсан тул Арвайхээр сумын 3-р багийн "Лаки" төвийн 1 давхарт байршиж үйлчилгээ явуулах тул хаягийн өөрчлөлт хийв.

---оОо---